



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 03 сарын 13 өдөр

Дугаар А/134

Булган сум

Мах нийлүүлэх ажил зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1, Хүнсний тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.5, Засгийн газрын 2022 оны "2022-2023 оны өвөлжилт, хаваржилтын болон ургац хураалтын бэлтгэл хангах тухай" 2022_9 дүгээр албан даалгавар, Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны ээлжит XII хуралдааны XII/21 дүгээр тогтоолын 3.2.15, аймгийн Засаг даргын "Шинэ хөгжлийн зам" үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөний 2.3.6.4 дэх заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн төвийн хүн амын 2023 оны хаврын улирлын хүнсний хэрэгцээнд мах бэлтгэн нийлүүлэх аж ахуйн нэгж, иргэнийг сонгон шалгаруулж, гэрээ байгуулан хэрэгжилтэд хяналт тавьж, ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Ч.Амгалан)-т үүрэг болгосугай.

2. Бэлтгэн нийлүүлж байгаа махны чанар, эрүүл ахуй аюулгүй байдалд тогтмол хяналт тавьж, ажиллахыг Мал эмнэлгийн газар (Г.Одсүрэн)-д даалгасугай.

3. Худалдаанд нийлүүлж байгаа махны өдөр тутмын гүйцэтгэлд хяналт тавьж, тооцоо нийлж ажиллахыг Булган сумын Засаг дарга (П.Нөхөрлөлбаяр)-д даалгасугай.

4. Гэрээний дагуу бэлтгэн нийлүүлсэн 1 кг мах тутамд 2500 (хоёр мянга таван зуу) төгрөгийн урамшууллыг батлагдсан төсвөөс санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Батцогт)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА  Б.АРИУН-ЭРДЭНЭ

